



# ГЛОБАЛ ЭДИЙН ЗАСАГТ ГАРЧ БУЙ ӨӨРЧЛӨЛТИЙН ТОЙМ

---

2022 оны 12 болон 13 дахь долоо хоног

---



## ГЛОБАЛ ЭДИЙН ЗАСАГТ ГАРЧ ГАРЧ БУЙ ӨӨРЧЛӨЛТИЙН ТОЙМ

2022 оны 03-р сарын 31-ний байдлаар

Энэ удаагийн танилцуулгад i) ОХУ-Украины мөргөлдөөний эдийн засагт үзүүлж буй нөлөө, ii) Нүүрсний зах зээлд гарсан өөрчлөлтийг тоймлон орууллаа.

1

### ОЛОН УЛСЫН ЭДИЙН ЗАСАГТ ӨРНӨЖ БУЙ ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДЛУУД

#### I.1 Хүнсний нийлүүлэлт, үнэд үзүүлэх нөлөө

Хүнсний нийлүүлэлт ОХУ, Украины мөргөлдөөн бий болохоос өмнө буюу 2020 оны дунд үеэс доголдон, үнэ нь тасралтгүй нэмэгдэж байна. Тодруулбал, олон улсад ган гачиг, их хэмжээний хур тунадас зэрэг цаг агаарын таагүй нөхцөл байдал<sup>1</sup> болон Ковид-19 цар тахлаас үүдэлтэй тээвэр логистикийн саатлаас шалтгаалж хүнсний үнэ мөргөлдөөнөөс өмнө сүүлийн 10 жилийн дээд түвшиндээ хүрээд байв. Нийлүүлэлт тогтворжоогүй үед хоёр орны хооронд мөргөлдөөн үүссэн нь дэлхийн нийтээр хүнсний нийлүүлэлтийн доголдол улам даамжрах, хүнсний аюулгүй байдал алдагдах нөхцөлийг үүсгэлээ. Энэ нь дэлхий дахинд эмзэг бүлгийн ард иргэдэд илүү хүндээр тусаж өлсгөлөнгийн аюулд нэрвэгдэж болзошгүй иргэдийн тоо огцом нэмэгдэх эрсдэл бодитоор бий болгож байна.

Ургамлын тос, улаанбуудай, эрдэнэ шиш зэрэг хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэлээрээ ОХУ, Украин улсууд дэлхийд тэргүүлдэг бөгөөд ихэвчлэн бага болон дунд орлоготой, ард иргэд нь хүнсний дутагдалд орж болзошгүй Ойрхи Дорнод, Зүүн Ази, Хойд

Африкийн олон улс орнуудыг хангадаг хүнсний томоохон экспортлогч орнууд юм. Түүнчлэн, Украин нь ядуу орнуудыг хүнсээр хангадаг НҮБ-ийн Хүнсний хөтөлбөрт хямд өртгөөр улаанбуудай нийлүүлэгч хоёрдогч том орон билээ. Мөргөлдөөнөөс хойш одоог хүртэл Хар тэнгис болон Азовын тэнгис дэх боомтууд хаалттай Украины экспорт зогсонги байдалтай байгаа бол ОХУ-ын дийлэнх бүтээгдэхүүний экспорт барууны орнуудаас тавьж буй хориг арга хэмжээний хүрээнд хязгаарлагдаад байна.

ОХУ, Украинаас экспортлож буй эдгээр хүнс нь анхдагч бүтээгдэхүүнүүд гэдэг утгаараа нийлүүлэлтийн гинжин хэлхээнд илүү өндөр ач холбогдолтой юм. Одоогийн байдлаар улаанбуудай, наранцэцгийн үрийг импортлон авч талх, паста, гурил, хүнсний тос зэрэг эцсийн бүтээгдэхүүнийг боловсруулж буй Турк, Египет, Арабын Нэгдсэн Эмиратын хүнсний үйлдвэрлэлд шууд нөлөө ажиглагдаж эхэлсэн бөгөөд цаашлаад эдгээр эцсийн бүтээгдэхүүнийг импортлогч Ливан, Тунис, Йемен, Ливи, Пакистан, Бангладеш зэрэг улс орнуудын хүнсний хэрэглээ хомсдох нь цаг хугацааны асуудал болоод байна.

<sup>1</sup> Ла Нина цаг уурын хэвийн бус төлөвөөс хамаарч Өмнөд Америкт ган гачиг, Зүүн Өмнөд Азид их хэмжээний хур

тунадас үүссэн. Түүнчлэн, АНУ, Канадад ажиглагдсан ган гачиг улаанбуудайн үйлдвэрлэлд нөлөөлсөн.

Хүснэгт 1: ОХУ, Украинаас экспортолж буй хүнсний бүтээгдэхүүний дэлхийн зах зээлд эзлэх хувь


	ОХУ	Украин	Нийт	ОХУ	Украин	Нийт
Улаанбуудай	18.4%	7.0%	<b>25.4%</b>	\$ 8.14 тэрбум	\$ 3.11 тэрбум	<b>\$ 11.25 тэрбум</b>
Эрдэнэ шиш	0.3%	0.49%	<b>0.79%</b>	\$ 5.83 сая	\$ 9.48 сая	<b>\$ 15.31 сая</b>
Наранцэцгийн үр	5.78%	1.12%	<b>6.9%</b>	\$ 255 сая	\$ 49.3 сая	<b>\$ 304.3 сая</b>
Наранцэцгийн тос	23.4%	45.8%	<b>69.2%</b>	\$ 1.73 тэрбум	\$ 3.4 тэрбум	<b>\$ 5.13 тэрбум</b>
Ургамлын тос	20%	34%	<b>54%</b>	\$ 2.2 тэрбум	\$ 3.75 тэрбум	<b>\$ 5.95 тэрбум</b>
Азотын бордоо	12.9%	0.75%	<b>13.65%</b>	\$ 3.05 тэрбум	\$ 179 сая	<b>\$ 3.23 тэрбум</b>

Эх сурвалж: Observatory of Economic Complexity (OEC), 2019 оны байдлаар

Украины газар тариалангийн үржил сайтай ихэнх бүс нутгийг ОХУ-ын зүгээс хяналтандаа оруулаад байна. Түүнчлэн, ОХУ мөргөлдөөнөөс урьтаж дэлхийд тэргүүлэх улаанбуудай импортлогчдын нэг БНХАУ-тай хөдөө аж ахуйн салбарт томоохон гэрээ үзэглэж, 2-р сарын 24-ны өдөр баталгаажуулсан явдал нь барууны орнуудаас тавигдах хориг арга хэмжээний нөлөөг саармагжуулах нэг төрлийн баталгаа болсон гэж шинжээчид дурджээ. Өмнө нь БНХАУ-ын зүгээс ОХУ-ын улаанбуудайнд хүнсний аюулгүй байдал хангахгүй

байгаа шалтгаанаар хориг тавьж зөвхөн 7 бүс нутгаас авто зам болон төмөр замаар экспорт хийж байсан. Харин уг гэрээний дагуу ОХУ-ын дурын бүс нутгаас сонгон улаанбуудай импортлох бололцоог олгосон ба БНХАУ-тай хийх улаан буудайн худалдаанаас Канад зэрэг барууны зах зээлийг шахан гаргасан. Өөрөөр хэлбэл, БНХАУ-ын дэмжлэгтэйгээр ОХУ-ын зүгээс олон улсын хүнсний нийлүүлэлтийн гинжин сүлжээг барууны орнуудаас хамааралгүйгээр өөрийн талд ашиглах боломж үүсэж байна.

Зураг 1: Хүнсний үнийн ерөнхий ба дэд бүлгийн индекс



Эх сурвалж: НУБ-ын Хүнс ба хөдөө аж ахуйн салбар байгууллага, 2022 оны 3-р сарын 4-ний байдлаар

### Олон улсын хүнсний зах зээлд үүссэн нөхцөл байдал

ОХУ, Украины мөргөлдөөний улмаас олон улсын зах зээл дээр хүнсний үнэ нэмэгдэх нөлөө дараах 2 байдлаар илэрнэ гэж шинжээчид дүгнэж байна. Үүнд нэгдүгээрт, дээрх бүтээгдэхүүнүүдийн үйлдвэрлэлд болон экспортын тээвэрлэлтэд доголдол үүсэх замаар хүнсний хомсдол үүсч энэ нь үнийг шууд өсгөх нөлөөтэй. Хоёрдугаарт, бордоо, тэжээл болон эрчим хүчний салбарт үнийн дарамт бий болоод байгаа нь хүнсний үнэд шууд бусаар нөлөөг үзүүлнэ. Мөргөлдөөн нь хүнсний бүтээгдэхүүний болон эрчим

хүчний үнэд ялгаатай нөлөөлөх боломжтой юм. Жишээлбэл, урт хугацаандаа хүнсний нийлүүлэлт, үнэ ямар түвшинд тогтох нь ОХУ-ын экспортын хэмжээний шийдвэр болон олон улсуудаас тавьж буй хориг арга хэмжээнээс шалтгаалан тодорхой бус байгаа бол газрын тос, байгалийн хийн хувьд урт хугацааны үнэ төдийлөн өөрчлөгдөхгүй байх өндөр магадлалтай. НҮБ-ын Хүнс ба хөдөө аж ахуйн салбар байгууллагаас гаргасан тооцооллоор геополитикийн хүндрэл үргэлжлэх хугацаа, хүндрэлийн түвшнээс хамааран хүнсний үнэ богино, дунд хугацаанд суурь төсөөллөөс 8-20 хувиар өсч болзошгүй гэж дүгнэжээ.

*Хүснэгт 2: Хүнсний үнэ богино, дунд хугацаанд суурь төсөөллөөс нэмж өсөх симуляцийн үр дүн*

Хугацаа =>	Богино		Дунд	
Нөхцөл байдал =>	Дундаж	Хурдацмал	Дундаж	Хурдацмал
Улаанбуудай	+ 8.7 %	+ 21.5 %	+ 10.3 %	+ 19.4 %
Эрдэнэ шиш	+ 8.2 %	+ 19.5 %	+ 8.5 %	+ 13.9 %
Бусад үр тариа (арвай, хөх тариа, овъёос, шар будаа)	+ 9.6 %	+ 20 %	+ 9.1 %	+ 15.4 %
Бусад тосны үр (рапс, наранцэцэг, газрын самар)	+ 10.5 %	+ 17.8 %	+ 8.5 %	+ 13.3 %
Хоол тэжээлийн дутагдалд нэмж орж болзошгүй хүн ам	+ 7.6 сая	+ 13.1 сая	+ 8.1 сая	+ 11.2 сая

*Эх сурвалж: НҮБ-ын Хүнс ба хөдөө аж ахуйн салбар байгууллага, 2022 оны 3-р сарын 11-ний байдлаар*







Улаанбуудай, эрдэнэшиш, ургамлын тосны дэлхийн зах зээл дээрх үнэ мөргөлдөөн эхэлсэн өдрөөс хойш хагас

сарын хугацаанд оргилдоо хүрч, эргэн тогтворжих хандлага ажиглагдаж эхлээд байна.

### Зураг 3. Дэлхийн зах зээл дээрх хүнсний үнэ, форвард хани

*/Тайлбар: Мөргөлдөөн эхэлсэн /2022.2.24/-ээс хойш форвард хани хэрхэн өөрчлөгдөж байгааг өнгөөр тодруулсан хэсэгт томруулан харуулав/*





Эх сурвалж: Блумберг, 2022 оны 3-р сарын 28-ны байдлаар

## Хүснэгт 3: Хүнсний зарим бүтээгдэхүүний зах зээл дээрх фьючерс гэрээний үнийн өөрчлөлт

Бүтээгдэхүүн	хэмжих нэгж	Үнэ			Өөрчлөлт (%)	
		1-р сар	Дайнаас өмнөх үе	3-р сарын 28	1-р сараас	Дайнаас өмнөх үеэс
Улаанбуудай	\$/бухал	7.6	8.8	10.8	42.2%	23.0%
Эрдэнэшиш	\$/т	255.0	302.9	372.3	46.0%	22.9%
Наранцэцгийн үр	\$/тонн	725.8	660.3	749.8	3.3%	13.6%
Дал модны тос	\$/тонн	1260.7	1554.3	1571.4	24.6%	1.1%
Шар буурцагны тос	\$/пунт	0.56	0.71	0.74	31.5%	4.5%
Бордоо (Шүвтэр)	\$/st <sup>2</sup>	730	545	930	27.4%	70.6%

Эх сурвалж: Блумберг

**1.2 Түүхий эдийн нийлүүлэлт, үнэд үзүүлэх нөлөө**

ОХУ-ын хувьд газрын тос, байгалийн хий, алт, нүүрс болон төмөр, хагас боловсруулсан төмрийн экспорт нь гол орлогыг бүрдүүлдэг буюу 2021 оны байдлаар нийт экспортын орлогын 45.6%-г эзэлсэн байна. Одоогийн үүсээд буй геополитикийн хүндрэл болон эдийн засгийн хориг арга хэмжээний нөхцөл байдлын үед дээрх түүхий эдийн зах зээлд гарч болох эрсдэл, нөлөөг анхаарч үзэх нь чухал ач холбогдолтой.

Түүхий эдийн захад гарсан өөрчлөлтийг авч үзвэл 1) АНУ, Европ орнууд ОХУ-аас татан авах түүхий эдийн хэмжээгээ бууруулах, хориг тавих, 2) ОХУ-д ноогдуулсан санхүүгийн хориг болон агаарын тээврийг хааснаас шалтгаалан нийлүүлэлтэд хязгаарлалт үүссэн, 3) ОХУ-ын зүгээс нийлүүлэлтээ бууруулах арга хэмжээг авч байна. Үүнээс шалтгаалан түүхий эдийн үнийн өсөлт нь эрчимжсэн бөгөөд мөргөлдөөний нөхцөл байдал удаан үргэлжлэх нь эрчим хүч болон автомашин, гар утас гэх мэт төмрийн төрлийн түүхий эд ихээр ашигладаг бараа, бүтээгдэхүүнүүдийн зах зээлд зардлыг нэмэгдүүлэх замаар инфляц, эдийн

засгийн өсөлтөд сөрөг нөлөө үзүүлэхээр байна (Зураг 3, 4). Түүхий эдийн зах зээлд үүсч буй нөхцөл байдлыг дараах хэсэгт дэлгэрүүлэн авч үзье.

**1. Газрын тос**

**Дэлхийн зах зээлд эзлэх хувь:** ОХУ дэлхийн газрын тосны экспортын 11%-г, Европын 30%-ийг нийлүүлдэг.

**Нийлүүлэлт тасалдах эрсдэл:** АНУ, Их Британи ОХУ-ын нефтийн импортод хориг тавьсан бол Европын холбоо үүнд шууд нэгдэх боломжгүй байгаа билээ. Гэтэл аль хэдийн эрэлт нийлүүлэлтийн тэнцвэргүй байдалд байгаа газрын тосны захад дахин шок үүсэв. Тодоруулбал, Йемений бүлэглэл 3-р сарын 25-ны өдөр Саудын Арабын газрын тос хадгалах байр луу халдаж, шатааснаар газрын тосны нийлүүлэлтэд сөрөг нөлөө үзүүлээд байна.

**Үр дагавар, үнийн төсөөлөл:** Шатахууны үнэ↑ → үйлдвэрлэлийн зардал↑, тээврийн зардал↑, хэрэглээний үнэ↑, хүндэрвэл стагфляц буюу бодит эдийн засгийн зогсонги байдал, өндөр инфляц.


Эрчим хүчний үнэ огцом өссөнөөр инфляц ирэх саруудад өндөр түвшинд хүрэх төлөвтэй байгаа бөгөөд төв

<sup>2</sup> 1 st = 14 пунт



банкуудын зорилтот түвшин рүү 2023 оноос аажмаар буурахаар байна. Богино хугацааны үнийн дарамт дэлхийн зах зээл дээрх газрын тос болон байгалийн хийн үнийн өсөлттэй холбоотойгоор огцом өсөж байгаагаас үүдэн Европын төв банк 2022 оны инфляцын төсөөллөө 1.9 нэгж хувиар нэмэгдүүлж 5.1 хувьд хүргэсэн байна. Европын төв банкны үзэж байгаагаар Украины нөхцөл байдал үргэлжлэхийн хэрээр газрын тосны үнэ \$100-с өндөр хэвээр удаан хадгалагдахаар байгаа бол байгалийн хийн үнэ багадаа 50 хувиар өсөхөөр

Зураг 2. Газрын тосны үнийн төсөөлөл



Тайлбар: McKinsey-с газрын тос, байгалийн хийн үнийг төсөөлөхдөө 3 хувилбарыг авч үзжээ. Үүнд: Мөргөлдөөн богино хугацаанд үргэлжлэх үед газрын тосны үнэ 90 орчим \$/баррельд хадгалагдах, 2022 оны сүүлийн хагаст дайн дуусах бол газрын тосны үнэ 100\$/баррельд хүрэх, урт хугацаанд үргэлжилж дайн эсрэг хүчтэй арга хэмжээ авбал газрын тосны үнэ 150\$/баррельд хүрэх хүлээлттэй. Байгалийн хийн хувьд геополитикийн эрсдэл хамгийн өндөр үед 68 орчим \$/MMBtu-д (энэ нь 2020 онд 10 ам.доллараас бага түвшинд байсан байна) хүрч өсөхөөр байна.

Эх сурвалж: McKinsey

## 2. Байгалийн хий


**Дэлхийн зах зээлд эзлэх хувь:** ОХУ байгалийн хийн нийт экспортын 19.9%-г эзэлдэг. Европын хэрэглээний 41.1%-г нийлүүлдэг.

**Нийлүүлэлт тасалдах эрсдэл:** Герман улс Nord Stream 2 шугамд зөвшөөрөл олгохгүй гэдгээ мэдэгдсэн. Хэрэв Европын орнууд ОХУ-аас авдаг газрын тосны хэмжээгээ бууруулж эхэлвэл

байна. Бусад байгууллагуудын төсөөллийг дараах хэсэгт тайлбарлая. Олон улсын байгууллагуудын үзэж байгаагаар газрын тосны үнэ багадаа 100\$/баррельд хадгалагдах, ихдээ 200\$/баррельд хүрэх хүлээлттэй.

**МCKinsey** (2022.03.23) ОПЕК+ нэгдэл төлөвлөгөөндөө хүрэхгүй байгаа, ОХУ Украины мөргөлдөөн, Арабын Нэгдсэн Эмират улс руу хийсэн халдлага зэргээс шалтгаалж 2022 оны эцэст газрын тосны үнэ 100\$/баррельд хадгалагдах хүлээлттэй.

Зураг 3. Байгалийн хийн үнийн төсөөлөл



Европтой холбогддог хийн хоолойн шугам (Nord Stream 1)-д хориг тавиж магадгүй талаараа ОХУ мэдэгдлээ.

Европын холбоо ОХУ-с хэт хамааралтай байдлыг өөрчлөхийн тулд Еврокомиссийн зүгээс 2022 оны 3-р сарын 9-нд ОХУ-ын нефть, байгалийн хий, нүүрснээс 2030 он гэхэд бүрэн татгалзах төлөвлөгөөг (REPower EU) танилцуулжээ. Ингэхдээ шингэрүүлсэн



байгалийн хийн импортыг нэмэгдүүлэх замаар хийн нийлүүлэлтийн төрөлжилтийг нэмэгдүүлэх, ОХУ-с бусад улсуудаас хийн хоолой татах, 2022 ондоо багтан ОХУ-с авдаг хийн импортоо 2/3-оор багасгахаар шийдвэрлэсэн байна.

Өнгөрсөн баасан гараг буюу 2022 оны 3-р сарын 25-ны өдөр АНУ-ын зүгээс Европын холбоонд нэмэлтээр 15 тэрбум куб.м шингэрүүлсэн байгалийн хийг энэ онд нийлүүлэхээр болов. Энэ нь Европын холбоо ОХУ-аас авдаг байгалийн хийн 10 хувь орчим хэмжээ юм. Гэвч энэхүү шийдвэр нь байгалийн хийн үнэд төдийлөн нөлөөлсөнгүй.

**Үр дагавар:** Эрчим хүчний үнэ↑ → Инфляц↑

Тухайлбал “Henry Hub”-ын байгалийн хийн үнэ ОХУ-Украины мөргөлдөөн эхлэхийн өмнө буюу 2022 оны 2-р сарын 23-ны өдөр **4.62\$/MMBtu** байсан бол 3-р сарын 11-ны байдлаар **4.73\$/ MMBtu** болж 2.4 хувиар нэмэгдээд байна. [S&P агентлагаас](#) Henry hub-ын байгалийн хийн төсөөллийг 2022 онд **0.5\$/MMBtu**-аар нэмэгдүүлж **4\$/MMBtu**, 2023 оны төсөөллийг **0.25\$/MMbtu** болгожээ. Харин 3-р сарын 8-ны байдлаар [Trading](#)

[Economics](#) тус төрлийн байгалийн хийн үнийг энэ улирлын эцэст **5.31\$/MMBtu** хүрэх, 12 сарын дотор **6.11\$/MMBtu**-д хүрэх төсөөлөл боловсруулсан байна.

### 3. Алт

**Дэлхийн зах зээлд эзлэх хувь:** ОХУ нийт экспортын 4.4%-г эзэлдэг.

**Нийлүүлэлт тасалдах эрсдэл:** Нийлүүлэлтээс төдийлөн шалтгаалдаггүй өвөрмөц онцлогтой цор ганц металл бол алт юм. Геополитикийн эрсдэл, тодорхой бус байдлаас шалтгаалж алтны үнэ 2-р сарын сүүлээс хойш төдийлөн буурахгүй 2022 оны 3-р сарын 25-ны өдрийн байдлаар **1958\$/унцад** хүрээд байна. Олон улсын судалгааны байгууллагуудын алтны үнийн төсөөллийг авч үзвэл:

[JP Morgan](#) (2022.03.09) зүгээс мөргөлдөөний нөхцөл байдал хурцдах, инфляц нэмэгдэхэд алтны үнэ **2200\$/унцад** хүрэх хүлээлттэй байна.

[Голдманн Сакс агентлагаас](#) (2022.03.10) алтны үнийг 2022 оны эцэст **350\$/унцаар** нэмэгдэж **2500\$/унцад** хүрэх төсөөллийг танилцуулав. Энэ нь ОХУ-Украины мөргөлдөөн эхлэхэд төсөөлж байсан дүнгээс **150\$/унциар** өндөр дүн юм.

Хүснэгт 4: Түүхий эдийн төлөв байдал

	ОХУ-ын 33-д эзлэх хувь	Нийлүүлэлт тасалдах эрсдэл	Үр дагавар	Орлуулах боломж
<b>Газрын тос</b>	Дэлхий - 11% Европ - 26.9%	АНУ, Европ, Англи ОХУ-аас авах газрын тос↓	Шатахууны үнэ↑ → Инфляц↑ → Стагфляц	ОПЕК+ нэгдэл болон АНУ-ын занар үйлдвэрлэгчид үйлдвэрлэл өсгөх сонирхолгүй
<b>Байгалийн хий</b>	Дэлхий - 19.9% Европ - 41.1%	ОХУ-ын зүгээс Европтой холбогддог хийн хоолойн шугамд хориг тавих	Эрчим хүчний үнэ↑ → Инфляц↑	Богино хугацаанд нүүрс ашиглаж эрчим хүч гарган авах (Герман, Итали хэрэглэгч орнууд гм); Урт хугацаанд сэргээгдэх эрчим хүч болон АНУ-с байгалийн хий авах





<b>Никель</b>	Дэлхий – 8.5%	Никелийн худалдаа↓	тээвэр, Цахилгаан автомашины зай, зэвэрдэггүй зэсийн үйлдвэрлэл↓, үнэ↑	Япон, Канад, Австрали, Норвегиос худалдан авах; Цахилгаан машиныг бензин хөдөлгүүрт машинаар орлуулах
<b>Паллади</b>	Дэлхий – 24.5%	ОХУ нь паллидигийн нийлүүлэлтээр дэлхийг тэргүүлдэг. Мөргөлдөөнтэй холбоотой нийлүүлэлт тасалдсан.	нь Автомашин, гар утасны үйлдвэрлэлийн зардал ↑	Англи, АНУ, Өмнөд Африк нь ОХУ-ын дараагаар орох паллидигийн нийлүүлэгч юм.

Эх сурвалж: Монголбанк

Хүснэгт 5: Түүхий эдийн үнийн өөрчлөлт, 1-р сар болон мөргөлдөөн эхлэх өмнөх үетэй харьцуулав.

Бүтээгдэхүүн	Хэмжих нэгж	Үнэ			Өөрчлөлт (%)	
		1-р сар	2-р сарын 11	3-р сарын 25	1-р сараас	Дайнаас өмнөх үеэс
Газрын тос	\$/баррель	85.6	94.4	120.7	10.3	27.9
Байгалийн хий	\$/MMBtu	4.3	3.9	5.57	-9.3	42.8
Никель	\$/тонн	22355.4	23701.5	35491	6.0	58.8
Паллади	\$/унц	2034.0	2253.0	2327	14.4	14.4

Эх сурвалж: Блүүмберг

### 1.3 Тээвэр, логистик, тээврийн үнэд үзүүлэх нөлөө

Тээвэрт үзүүлж буй нөлөө, үр дагаврыг багцлан авч үзвэл:

- Газрын тосны үнэ өсөж, бүх төрлийн тээврийн зардал, үнэ нэмэгдэхээр байна.
- Олон улсын агаарын зам танагдсанаар агаарын тээврийн хүчин чадал 10 хувиар буурч, агаарын тээврийн үнэ өсөхөөр байна.
- ОХУ-аар дамждаг Ази-Европын газрын ачаа тээвэр саатах өндөр эрсдэлтэй байгаа бөгөөд хэрэв саатвал далайн тээвэрт шилжихээр байна.
- Далайн тээврийн ачаалал, үнэ нэмэгдэх хандлагатай. Улмаар дэлхийн нийлүүлэлтийн сүлжээний доголдол үргэлжлэх, улам хүндрэх эрсдэлтэй байна.

Тээврийн нөхцөл байдлыг төрөл тус бүрээр нь дэлгэрүүлж үзье.

#### 1. Далайн тээвэр

- **Нөхцөл байдал:** Их Британи ОХУ-ын усан онгоцуудад хориг тавьж, боомтдоо хүлээж авахаас татгалзсан бол Европын холбоо мөн удахгүй татгалзана гэдгээ мэдэгдэв. Харин Украины бүх далайн боомтууд хаагдаад байна. Мөн ОХУ, Украины ойролцоо Хар тэнгис, Азовын тэнгисийн хэсгийг улаан жагсаалтад оруулснаар тэр бүсээр далайн тээвэр хийхэд хүндрэлтэй болсон байна.
- Тээврийн үйлчилгээ үзүүлдэг БНХАУ-н COSCO, Тайванийн Evergreen Line компаниудын ОХУ-тай хийх тээврийн үйл ажиллагаа нь тодорхойгүй төлөвт байгаа бол дэлхийн далайн тээврийн бусад бүх том компаниуд ОХУ, Украин улсын далайн тээврийн захиалгыг зогсоов.



- **Үр дагавар:** далайн тээвэр доголдох, далайн тээврийн үнэ  $\uparrow \rightarrow$  дэлхийн нийлүүлэлтийн гинжин сүлжээ саатах, үйлдвэрлэл  $\downarrow$ , үйлдвэрлэлийн үнэ  $\uparrow$
- **Орлуулах боломж:** Украины боомтууд хаагдсанаар уг боомтуудаар дамжин тээвэрлэгдэж байсан БНХАУ-Европын чиглэлийн далайн тээврийг Румын, Лэбанон, Грекийн боомтууд руу шилжүүлж эхлээд байна.

## 2. Агаарын тээвэр

- **Нөхцөл байдал:** ОХУ 36 орны эсрэг агаарын хилээ хаасан. Ингэснээр олон улсын агаарын замын чиглэлээс 10 сая миль (16.4 сая км) буюу дэлхийн агаарын замын 11 хувьтай тэнцэх зам хасагдсан. Дэлхийн хамгийн том агаарын тээврийн хөлөг “Антонов” ОХУ-Украины мөргөлдөөний үеэр сүйдэв.
- **Үр дагавар:** 1) Нислэгийн тоо  $\downarrow \rightarrow$  Агаарын тээврийн хүчин чадал  $\downarrow$  2) онгоцны түлшний зардал  $\uparrow$ , агаарын татварын зардал  $\uparrow \rightarrow$  агаарын тээврийн зардал  $\uparrow$ , зорчигч тээврийн үнэ  $\uparrow$  3) агаарын нислэгийн компаниудын ашиг  $\downarrow$
- **Freightos**-оос зарладаг Шанхайгаас Хойд Европыг чиглэсэн агаарын ачааны өртөг 3-р сарын 20-ны байдлаар 8.66 ам.доллар/кг болж 2-р сарын эцсээс 39 хувиар өсөв.

## 3. Төмөр замын тээвэр

- **Нөхцөл байдал:** Украинаар дамжих транзит тээвэр бүрэн зогссон, бусад чиглэлийн (Беларусиар дамжих) транзит тээвэр хэвийн үргэлжилж байна. Цаашид Беларусиаар дамжих транзит тээврийг зогсоох магадлал улам бүр нэмэгдсээр байна. БНХАУ-Европын төмөр замаар тээвэрлэж байсан зүйлс усан тээвэрт шилжиж байна.

- **Үр дагавар:** Төмөр замын ачаа тээвэрт үүсэх саатал нь далайн тээврийн ачааллыг нэмэгдүүлэх, мөн Европт үүсээд буй контейнерийн хүрэлцээ, түгжрэлийн асуудлыг улам хүндрүүлэхээр байна.

- **Орлуулах боломж:** Турк улсаар дамжих өмнөд зүгийн гарцыг ашиглаж болно. Гэвч Каспийн тэнгисийн холбоост үүсээд буй ачаалал, гацааны асуудлаас шалтгаалж одоогоор тухайн чиглэлээр тээх ачааны хэмжээг огцом нэмэгдүүлж чадахааргүй байна.

### ■ Авто замын тээвэр

- **Нөхцөл байдал:** ОХУ-Украины мөргөлдөөнөөс шалтгаалж авто замын томоохон тээвэрлэгчид (UPS, FedEx, DHL) ОХУ, Украинд үйл ажиллагаагаа зогсоосон бол зарим жижиг тээвэрлэгчид үйл ажиллагаагаа үргэлжлүүлж байна.
- **Орлуулах боломж:** Авто замын тээврийн өөр боломжит хувилбараар Турк, Өмнөд Кавказаар дамжих чиглэл яригдаж байгаа ч мөргөлдөөний бүс нутагт ажиллах жолооч, ажиллах хүчний хомстол үүсэж болзошгүй.

## 1.4 Инфляц, эдийн засгийн өсөлтөд үзүүлэх нөлөө

*Инфляц, эдийн засгийн өсөлтөд үзүүлж буй нөлөө, үр дагаврыг багцлан авч үзвэл:*

- ОХУ-Украины мөргөлдөөнтэй холбоотойгоор тодорхой бус байдал эрс нэмэгдээд байна.
- ОХУ-Украины мөргөлдөөний нөлөө нь санхүүгийн хориг арга хэмжээ, түүхий эдийн үнийн өсөлт, нийлүүлэлтийн сүлжээний доголдол зэрэг сувгуудаар дамжин эдийн засагт нөлөө үзүүлэх бөгөөд эдийн засгийн өсөлт саарч, инфляц



эрчимжиж, стагфляцын эрсдэлийг нэмэгдүүлнэ гэж ихэнх гадаад эх сурвалжууд үзэж байна.

- Үүссэн нөхцөл байдлаас үүдэн газрын тос, байгалийн хий, зарим төрлийн хүнсний нийлүүлэлт тасалдсанаас үнэ өсч, улмаар шууд болон шууд бус замаар инфляцыг өсгөх төлөвтэй байна. Зарим эх сурвалжийн эхний тооцооллоор Евро бүс болон дэлхийн инфляц дунджаар 1-3 нэгж хувиар нэмэгдэх төсөөлөлтэй байгаа төдийгүй үүнээс ч өндрөөр өсөх эрсдэл байгааг дурджээ.
- Нийлүүлэлтийн сүлжээ доголдох, үйлдвэрлэлийн зардал өсөх, санхүүгийн зах зээл дээрх тодорхой бус байдал нэмэгдэх зэргээс шалтгаалж улс орнуудын эдийн засгийн өсөлт саарахаар байна. Энд ОХУ болон Украины эдийн засгийн өсөлт хамгийн ихээр саарахаар байгаа бол ОХУ-тай худалдаа их хийдэг Евро бүсийн эдийн засагт мөн хүчтэй нөлөө үзүүлнэ гэж үзжээ.
- Цар тахлын үеэр улс орнуудын авч хэрэгжүүлсэн бодлогын арга хэмжээнээс шалтгаалж төсөв болон мөнгөний бодлогын орон зай хязгаарлагдмал болоод байгаа энэ үед бодлого боловсруулагчид

дайны үр нөлөөг анхааралтай тооцоолж, олон нийтэд зөв дохио өгч ажиллах, нэн ядуу иргэдийг дэмжих нь чухал байна.

Энэ долоо хоногт дэлхийн эдийн засаг болон бүс нутгийн эдийн засгийн өсөлт, инфляцад үзүүлэх нөлөөг шинэчлэн тооцсон эх сурвалжийг дэлгэрүүлж үзье.


### 1. *Mckinsey* байгууллагын төсөөлөл (3 сарын 23)

[Mckinsey](#) байгууллагаас ОХУ-Украины дайны Евро бүсийн эдийн засаг, инфляцад үзүүлэх үр нөлөөг 3 хувилбараар төсөөлжээ.


1. Хувилбар 1. ОХУ-Украины хэлэлцээр ойрын хэдэн 7 хоногт зөвшилцөлд хүрч, хоёр тал галаа зогсоох, зарим дүрвэгсэд гэртээ эргэн ирэх, эрчим хүч, түүхий эдийн үнэ тогтворжих, үнэ нормалчлагдах,
2. Хувилбар 2. ОХУ-Украины мөргөлдөөн 2022 оны сүүлийн хагаст намжих,
3. Хувилбар 3. ОХУ-Украины мөргөлдөөн илүү удаан үргэлжлэх, Зүүн Европод цагаачлалын хямрал хурцдах, эрчим хүчний үнэ болон үнийн спирал өсөлт үүсэх



4. Зураг 4. Евро бүсийн эдийн засгийн өсөлтийн төсөөлөл



Зураг 5. Евро бүсийн инфляцын төсөөлөл



Эх сурвалж: Mckinsey


Нөхцөл байдал хамгийн хүндрэх Хувилбар 3-т хэрэглэгч, хөрөнгө оруулагчдын итгэл унаж, Евро бүс болон АНУ-ын эдийн засаг 2022 онд агших, Евро бүсийн инфляц 7 хувь хүрч өсөх эрсдэлтэй байна.

2. S&P Global байгууллагын төсөөлөл (3 сарын 22)

S&P Global байгууллага энэ оны 2-р сард дэлхийн эдийн засаг 4.1 хувиар өсөхөөр төсөөлж байсан бол 3-р сар уг төсөөллийг 3.3 хувь болгож буурууллаа. Өсөлтийн төлөвийг ийнхүү муутгахад -0.3 нэгж хувь нь ОХУ, Украины эдийн

засгийн огцом агшилтаас, -0.3 нэгж хувь нь Евро бүсийн эдийн засгийн бууралтаас бий болохоор байна. ОХУ-Украины мөргөлдөөнтэй холбоотойгоор нийлүүлэлтийн доголдол үргэлжилж, түүхий эдийн үнэ өсч байгаа нь Дундад Ази, Хойд Африкаас бусад бүх бүс нутгийн өсөлтөд сөргөөр нөлөөлөхөөр байна. Түүхий эд, эрчим хүчний үнэ өсч, глобал инфляцын төсөөлөл өмнөх сарын төсөөллөөс 1.8 нэгж хувиар нэмэгдэн, энэ онд 6.4 хувьтай гарахаар байна. Энэ нь 1995 оноос хойших хамгийн өндөр инфляцын түвшин болох юм.

Зураг 6. Эдийн засгийн өсөлтийн төсөөлөл



с: S&P Global Market Intelligence

■ World ■ United States ■ Eurozone ■ Japan ■ Mainland China ■ Russia

© 2022 S&P Global

Эх сурвалж: S&P Global



### Коксжих нүүрсний зах зээл

- **Үнэ:** БНХАУ-ын мужуудад коксжих нүүрсний үнэ нэмэгдсэн бол боомтууд дээрх үнэ буурав. Тухайлбал, 2022 оны 3-р сарын 25-ны байдлаар Хэбэй мужид коксжих нүүрсний үнэ тонн тутамд 2 долоо хоногийн өмнөхөөс 200 юаниар нэмэгдэж 3,560 юань (561\$), Шаньси мужид мөн 200 юаниар нэмэгдэж 3,360 юань (529\$)-д хүрэв. Харин Таньжин боомтод коксжих нүүрсний үнэ өмнөх 2 долоо хоногоос 110 юаниар буурч 3,520 юань (554\$)-д хүрээд байна.
- **Эрэлт:** Хэдийгээр өсөлтийг тогтворжуулах бодлого, бусад тэлэх чиглэлийн макро бодлогууд хэрэгжүүлж байгаа нь нүүрсний эрэлтийг дэмжих хэдий ч нөгөө талаас КОВИД-19 цар тахалтай холбоотойгоор зарим мужуудад хөл хорио тогтоосон нь эрэлтэд томоохон сөрөг нөлөө үзүүлж байна.
- **Нийлүүлэлт:** Коксжих нүүрсний нийлүүлэлт өмнөх 2 долоо хоногоос буурав. Тухайлбал, Өвөр Монголд явуулсан хүрээлэн буй орчны хяналт шалгалтаас шалтгаалж нүүрсний нийлүүлэлт ялимгүй буураад байна. SXcoal судалгааны байгууллагын судалгаанд хамрагдсан нүүрсний үйлдвэрүүдийн хүчин чадлын ашиглалт 3-р сарын 24-ний байдлаар 101 хувьд хүрч өмнөх 2

долоо хоногоос 1 хувиар буураад байна.

- **Нөөц:** Цар тахлын эсрэг авсан хариу арга хэмжээний улмаас нийлүүлэлт эрэлтээс давснаар нүүрсний үйлдвэрүүдийн нүүрсний нөөц нэмэгдлээ. Тухайлбал, SXcoal судалгааны байгууллагын судалгаанд хамрагдсан БНХАУ-ын үйлдвэрүүдийн угаасан нүүрсний нөөц 2022 оны 3-р сарын 24-ний байдлаар өмнөх 2 долоо хоногоос 210 мянган тонноор нэмэгдэж 890 мянган тоннд хүрэв.
- **Цаашдын хүлээлт:** Цаашид КОВИД-19 цар тахлын эсрэг авч буй хориг арга хэмжээнүүд, нүүрсний эрэлтэд үзүүлж буй нөлөөнөөс шалтгаалж нүүрсний үнэ өөрчлөгдөхөөр байна.

### Монголын нүүрсний экспорт

- Цар тахлын нөхцөл байдал сайжирснаар Монголын нүүрсний экспорт нэмэгдэж байна. Гашуунсухайт-Ганцмод боомтоор нэвтэрсэн ачааны машины тоо 204-д хүрч өмнөх 7 хоногийн дундажаас 14-өөр нэмэгдэв. Мөн тус боомтоор нэвтэрсэн нүүрсний үнэ өмнөх 2 долоо хоногоос өөрчлөлтгүй 2,460 юаньд (387\$) хэвээр хадгалагдав.
- Шивээхүрэн-Сэхэ боомт хаалттай хэвээр байгаа бөгөөд тус боомт дээрх коксжих нүүрсний үнэ өмнөх 7 хоногоос өөрчлөлтгүй, 1,550 юань (\$243) хэвээр байна.

## Экспортын голлох түүхий эдийн дэлхийн зах зээл дээрх үнийн өөрчлөлт

/2022 оны 3-р сарын 30-ны байдлаар/

Бодит гүйцэтгэл						
	Үнэ	Өөрчлөлт				Товч тайлбар
	(-1 day) 2020/10/16	daily	weekly	monthly	year to date	
Зэс	<b>10,368</b>	0.5	-0.7	4.9	5.5	Нэг тонн зэсийн үнэ 3-р сарын 30-ны байдлаар 10,368 ам.долларт хүрч өсөв. Металлын биржүүд дээр буураад байсан зэсийн нөөц төдийлөн нэмэгдээгүй, нийлүүлэлтийн гинжин сүлжээний доголдол үргэлжилж байгаа зэргээс шалтгаалж зэсийн үнэ ийнхүү өндөр түвшинд хадгалагдлаа.
Төмрийн хүдэр	<b>136</b>	-5.0	2.1	19.5	-23.9	Нэг тонн төмрийн хүдрийн үнэ 3-р сарын 30-ны байдлаар 136 болж нэмэгдлээ. Хэдийгээр Бээжин 2022 олимп зохион байгуулагдаж, БНХАУ-ын Засгийн газрын зүгээс гангийн үйлдвэрлэлд хязгаарлалт тавьсан ч 2022 оны эхний 2 сард төмрийн хүдрийн импорт өндөр түвшинд хадгалагдсан нь БНХАУ-ын төмрийн хүдрийн эрэлт өндөр байгааг илтгэж байна. Түүнчлэн, олимп дуусаж гангийн үйлдвэрлэлд хязгаарлалт тавихаа больсон, БНХАУ-ын Засгийн газрын өсөлтийг тогтворжуулах, дэд бүтцийг дэмжих бодлогын нөлөөгөөр төмрийн хүдрийн үнэ өндөр түвшинд байна.
Алт	<b>1,933</b>	0.7	-0.6	1.3	-14.7	Нэг унц алтны үнэ 3-р сарын 30-ны байдлаар 1933 долларт хүрэв. Геополитикийн эрсдэл, тодорхой бус байдал өндөр байгаа, инфляц өндөр түвшинд байгаа зэргээс аюулгүй хөрөнгө оруулалт болох алтны эрэлт өсч, алтны үнэ 2000\$/унц руу дөхөөд байна.
Газрын тос (Брент)	<b>113.5</b>	2.9	-6.7	12.3	76.9	Брент маркын нэг баррель газрын тосны үнэ 3-р сарын 30-ны байдлаар 113.5 ам.долларт хүрлээ. Газрын тосны эрэлт өндөр түвшинд хадгалагдсан ч нийлүүлэлт доголдоод байгаа нь үнэ 100\$/баррелиас өндөр байхад голлон нөлөөлж байна. Тухайлбал, Барууны орнууд ОХУ-аас худалдан авах газрын тосны хэмжээг бууруулахаа мэдэгдсэн, Йемений Хутис босогчид газрын тосны гол нийлүүлэгч болох Саудын Араб, Арабын Нэгдсэн Эмират улс руу довтолсон зэрэг нь нийлүүлэлтийн тодорхой бус байдлыг нэмэгдүүлээ.

**Ашигласан материалууд:**

- SX Coal, Weekly Update, January 29<sup>th</sup>, 2022
- SX Coal, Weekly Update, February 7<sup>th</sup>, 2022
- [http://www.stats.gov.cn/english/PressRelease/202202/t20220207\\_1827228.html#:~:text=Purchasing%20Managers%20Index%20for%20January%202022&text=In%20January%2C%20the%20Purchasing%20Manager,of%20manufacturing%20expansion%20slowed%20down.](http://www.stats.gov.cn/english/PressRelease/202202/t20220207_1827228.html#:~:text=Purchasing%20Managers%20Index%20for%20January%202022&text=In%20January%2C%20the%20Purchasing%20Manager,of%20manufacturing%20expansion%20slowed%20down.)
- <https://blinks.bloomberg.com/news/stories/R73R36T1UM14>
- <https://blinks.bloomberg.com/news/stories/R74E19T0AFB4>
- <https://continuumeconomics.com/2021/12/20/outlook-overview/charting-our-views-december-2021>
- <https://continuumeconomics.com/2022/02/01/emerging-markets/ukraine-war-impact-russia-the-west-and-em>
- <https://thedocs.worldbank.org/en/doc/a8b46c2ac87710fa9694cb6ae1a891fa-0350012022/original/Global-Monthly-Jan22.pdf>
- <https://www.fao.org/worldfoodsituation/foodpricesindex/en/>
- <https://www.federalreserve.gov/monetarypolicy/files/monetary20220126a1.pdf>
- <https://www.imf.org/en/Publications/WEO/Issues/2022/01/25/world-economic-outlook-update-january-2022>
- <https://www.mining.com/iron-ore-price-rise-to-150-after-beijing-eases-steels-green-targets/>
- [https://www.opec.org/opec\\_web/en/press\\_room/6796.htm](https://www.opec.org/opec_web/en/press_room/6796.htm)
- <https://www.reuters.com/business/energy/oil-extends-gains-above-90bbl-winter-storm-sweeps-through-united-states-2022-02-04/>
- <https://www.reuters.com/business/new-lme-stocks-squeeze-is-creeping-up-doctor-copper-andy-home-2022-02-08/>
- [https://www.un.org/development/desa/dpad/wp-content/uploads/sites/45/publication/WESP2022\\_web.pdf](https://www.un.org/development/desa/dpad/wp-content/uploads/sites/45/publication/WESP2022_web.pdf)
- <https://www2.deloitte.com/us/en/insights/economy/global-economic-outlook/weekly-update.html>
- <https://www.reuters.com/markets/europe/iron-ore-outlook-is-more-bullish-than-lower-china-growth-target-suggests-russell-2022-03-07/>
- <https://www.bbc.com/news/world-middle-east-29319423>